



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2021 оны 02 сарын 16 өдөр

Дугаар

А/НН

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1.4, 67.5-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ховд аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 153\ШШ2018\00726 дугаартай шийдвэрт заасан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Тариалан эрхлэлтийг дэмжих санд төлөх тракторын үнэ болох 1.088.365.000 төгрөгийг сумдын Засаг даргын Тамгын газар болон худалдан авсан иргэдээр төлүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч : Ш.Нохойжав - Орон нутгийн өмчийн газрын дарга

Гишүүд: Ч.Эрдэнэбат - Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн

Б.Түмэнжаргал - Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн

Р.Тогтохбаяр - Хүнс, хөдөө ахуйн газрын мэргэжилтэн


Нарийн бичгийн

дарга: Ц.Пүрэвсүрэн - Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө  
оруулалтын хэлтсийн мэргэжилтэн

2. Ажлын төлөвлөгөө батлуулан, сумдын Засаг даргын Тамгын газар болон бусад холбогдох байгууллагатай хамтран ажиллаж ажлын үр дүнг 2021 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн дотор цаашид хэрэгжүүлэх саналын хамт танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Ш.Нохойжав)-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Н.Ганзориг)-д даалгасугай.

ДАРГА



Д.ЭНХБОЛД

8400 03 0247  
D/Tush-A/44-Bo